

БАТЛАВ: СУМЫН ЗАСАГ ДАРГА



Б.ЭРДЭНЭБААТАР

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Монгол Улсын Хүнс, Хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”, MNS 6088:2011 стандарт, 2014 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн А/26 тушаалыг тус тус мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

1. Худгийг сэргээн засварлах, шинээр барихаас өмнө ба дараах үеийн гэрэл зургийг нэг цэгээс авч, худгийн солбилцолыг нарийвчлан тодорхойлсон байна.
2. Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS6088:2010 стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтын ажлыг явуулах ажлыг гүйцэтгэнэ.
3. Уст цэгийн хайгуул, эхний цооногийн голч 245 мм - 325 мм диаметртэй өрөмдөх, шавхалт туршилтын ажил хийх.
4. Газрын доорхи геофизикийн хайгуулыг үндэслэн сум орон нутгийн газарзүйн байршлаас хамаарч худаг гаргах өрөмдлөгийн цооногны гүн 50-150 метр байна.
5. Ашиглалтын ундарга нь 0.6 л/с-ээс доошгүй байх, цооногийн техникийн паспортыг хөтөлж сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгөх.
6. Хайгуулын ажлаар уст цэгийг тогтоох ажлыг хийж, энэ тухай актыг бүрдүүлэх, ашиглаж болохуйц энгийн болон инженерийн хийцтэй худгийн дэргэд шинээр худаг гаргахгүй байвал зохино.
7. Худгийн цооногийн хийц зохиомжийг MNS6088-2010 стандартын шаардлагад нийцүүлэн, өрөмдлөгийн ажлын дараах шавхалтын ажлын үр дүнгээр худгийн ундарга 0,6 л/с-ээс бага бол цооног ашиглах боломжгүй гэж үзэх ба Мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулах шаардлагатай.
8. Тухайн гидрогеологийн нөхцөлд, усны динамик түвшин нь хамгийн бага гүнд байхад шаардлагатай ундаргыг хангасан байхаар тооцож, цооног өрөмдөх, худгийн цооногийн шүүрийн цувааны диаметр нь түүний дотуур ус шахуургыг саадгүй суулгах, дахин сугалах боломжтой байх, чанарын хувьд шаардлага хангасан ашиглах боломжтой уст үеийг бусад шаардлага хангахгүй уст үеэс сайтар зааглаж хаасан байх.
9. Худгийн цооногийг чулуулгийн уст үе, бусад үе давхаргын элс шавар гэх мэт сэвсгэр болон үйрмэг чулуу нурж унахгүй нөхцлийг хангахаар бодож суултын яндангаар сайтар хааж бэхлэх, шаардлагатай тохиолдолд шүүрийн цувааны доод амсрыг битүүлж таглах,

цооногийн хийц зохиомж нь түүнийг ашиглах ба сэргээн засварлахад төвөгтэй биш байвал зохино. Өрөмдлөгийн ажлын журнал хөтөлнө.

10. Өрөмдлөгийн ажлын үед өрөмдлөг болон шүүрийн яндангийн диаметр 159 мм-ээс багагүй, шүүрийн яндан ус шахуургын диаметрын зөрүү 50 мм-ээс багагүй байхыг, шүүрийн яндан суулгаагүй үндсэн чулуун ханатай цооногийн диаметр ус шахуургын диаметрын зөрүү 50 мм-ээс бага байхыг тус тус техникийн хувьд хориглоно. Өрөмдлөгийн ажил дууссаны дараа шавхалтын ажлыг хийж гүйцэтгэх ба шавхалтын журналыг дэлгэрэнгүй үйлдэх
11. Усны химийн болон бактериологийн шинжилгээг Мэргэжлийн Хяналтын Газар, усны мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүнг хавсаргах
12. Уст цэгийн геоцахилгаан зүсэлтийг хавсралтын дагуу бэлтгэх. Усгүй буюу хэт бага устай гэж тодорхойлогдсон газар өрөмдөж илүү зардал гаргахгүй байхад анхаарах
13. Худаг шинээр гаргах сэргээн засварлах, уст цэгт захиалагч, усны мэргэжлийн байгууллагатай хамтран энэ журмын 1 дүгээр хавсралт Акт ¹1-ийн дагуу акт бичиж, жилийн бүрийн 06 дугаар сарын 30-ны дотор Ерөнхий захиалагчид ирүүлэх ба засварласан, шинээр гаргасан худаг, уст цэгийг гүйцэтгэгчтэй хамтран захиалагч, өмчлөгч, эзэмшигчийн төлөөлөгчийг байлцуулан энэ журмын 2 дугаар хавсралт Акт ²2-ын дагуу акт бичиж, сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгөх ажлыг хэрэгжүүлэх;
14. Далд ажлын актыг энэхүү журмын 3 дугаар хавсралт Акт ³3-ын дагуу үйлдэж, гүйцэтгэл хавсаргах;
15. Төсөл, хөтөлбөр хэрэгжих хугацаанд сэргээн завсарласан, шинээр гаргасан худаг, уст цэгийн эзэмшил, ашиглалтад хяналт тавих;
16. Шинээр гаргасан худаг, уст цэгийн төрөл үзүүлэлт, эзэмшил, ашиглалтын талаархи тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Ерөнхий захиалагчид гаргаж өгөх.
17. Шинээр гаргаж буй худгийн цооногийг гаргаж, худгийн гүн, ундарга, статик, динамик түвшин зэргийг бүрэн тодорхойлсны дараа насосыг сонгон авч угсрах нь зүйтэй.
18. Багт бүрт гаргасан цооног бүрт 220ВТ-н цахилгаан мотор, чандал нь EP1000 CX байх
19. Багийн Засаг дарга нарыг байлцуулан худаг хүлээх авах комисст хүлээлцэх, худгийн эзэмшил ашиглалтын талаар заавар өгч, эзэмшигчийг тодруулсан тухай хурлын тэмдэглэл хөтөлж ирүүлэх.